**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/504

Номгон

Б.Бат-Оршиход хүндэтгэл үзүүлж,
мөнгөн шагнал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.3, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 90 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар баталсан “Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалтын нийтлэг журам” ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.“Тулгар Төрийн 2229 жилийн ой, Их Монгол улс байгуулагдсаны 814 жил, Ардын хувьсгалын 99 жилийн ойн үндэсний их баяр наадамд зургаа давж улсын харцага цол хүртсэн Батсуурийн Бат-Оршиход хүндэтгэл үзүүлж мөнгөн шагнал олгосугай.

2.Улсын харцага Б.Бат-Оршиход хүндэтгэл үзүүлэхэд Засаг даргын нөөц хөрөнгөөс 30.000.000 /гучин сая/ төгрөгийг зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа) -д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэргэжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.

4.Аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/484 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

601210163

D:\2021\Zakhiramj-2021 on\Захирамж-2021 он.docx